

## МОНГОЛЧУУДЫН ТЭНГЭР ШҮТЛЭГИЙН ХУВЬСАЛ

**С.БЯМБАДОРЖ**

*Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Угсаатан судлалын тэнхим, e-mail: Rdorje2002@yahoo.com*

*Түлхүүр үг. Тэнгэр, Мөнх тэнгэр, Заяа таван тэнгэр, Сан, бөө, лха*

*Өгүүллийн товч агуулга. Уг өгүүлэлд Монголчуудын уугуул шүтлэг болох тэнгэр шүтлэг, түүний шинж чанар хийгээд ламын шашин дэлгэрсэнтэй холбогдсон түүний хувьсал өөрчлөлт, түүнийг лам нар хэрхэн халсан тухай асуудлыг товч авч үзлээ*

Төв Азийн эртний нүүдэлчид тэр дундаа ХТӨ үеэс нүүдэлчний хүчирхэг төр улс байгуулж байсан хүн(нү)чүүдээс эхлэн хөх тэнгэрийг бишрэн шүтэж хувь заяа аж амьдралаа түүнд даатган дээдэлж ирсэн түүхтэй. Дөрвөн цагийн улиралд бэлчээр хөөн нүүдэллэж амьдралынхаа ихэнх хэсгийг хөх тэнгэрийн дор өнгөрөөгч нүүдэлчин ард түмний ахуй амьдрал бүхлээрээ тэнгэрийн эрхшээлд оршин байсан нь тэнгэр шүтэх нөхцөл болох нь ойлгомжтой. Цаг түүхийн эргэлтэд их говийн хойд өндөрлөгийг эзлэн орших болсон Сяньби, Жужан нар ч тэнгэрийг дээдлэн шүтэж, хожмын түрэг аймгууд ч “Худай” хэмээх тэнгэр, “Умай” хэмээх газар шүтээнтэй байсан тухай сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Тэнгэр шүтлэг XIII зууны үеийн монголчуудад шүтлэгийн үндсэн хэлбэр болж түүгээр ч барахгүй Монголчуудын үндсэн үзэл суртал, голлох шашин болж байсныг судлаач эрдэмтэд тэмдэглэсэн байдаг.

XIII зууны үеийн монголын гайхамшигт сурвалж бичиг болох “Монголын нууц товчоон”д “tenggeri i[t]qan aqu-un ke’eju”/Тэнгэр ятган амуу хэмээж/, “haci qari’ ulqu-yi tenggeri gajar-un iheel medetugei ke’eba ”/ач хариулахыг тэнгэр газрын ивээл мэдтүгэй хэмээв/ , tenggeri –de ulu ta’alaqdaqun”/тэнгэрт үл таалагдан/, tenggeri-de maqata’ ta’alaqdahun/тэнгэрт магад таалагдан”, tenggeri-de ihe’elde’esu/тэнгэрт ивээгдвээс/, mongke tenggeri-yin qucun-tur tenggeri gajar-a qucu auqa nemekdeju/мөнх тэнгэрийн хүчин дор тэнгэр газараа хүч аугаа нэмэгдэж”, “tenggeri gajar eyetu[l]duju/тэнгэр газар эелэлдэж/, “Bida qor-qonaq-jubur-un qutula-qan-un de[b]sequ saglar modun-a bawu’asu muqali-da tenggeri-yin ja’arin ja’agsan uge temteg—un tula bi gu’un-qo’a-yi setkiju muqali-da uge baralu’a”, “Teb Tenger Chinqqis – qa’an-a ugulerun mongke tenggeri yin jarlig qan ja’arit ugulemu. Nikente temujin ulus barituqai” (Rachewiltz 1972: 31, 76, 79, 121, 128, 206,

244) зэргээр тэнгэр шүтээний талаар олонтоо дурдсан байдаг. Өгөдэй хаан, Гүюг хааны тамга, Ил хаадын бичээсүүд ч монголчууд ивээгч шүтээнээ мөнх тэнгэр хэмээн үздэг байсныг баталж байдаг. “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын Далай хааны зарлиг. Эл булха иргэнд хүрвээс биширтүгэй. айтугай” хэмээх тамганы үг, Гүюг хаанаас Ромын Пап ламд бисэн захидлын агуулга зэргээс үзэхэд монголчууд өөрсдийгөө тэнгэрийн заяат хүмүүс гэж итгэдэг байсан нь тодорхой юм. Хэдий Монголын утга зохиол, билэг зүйн дурсгалуудад 99 тэнгэр, 13 тэнгэр, 9 тэнгэр, 5 тэнгэрийн тухай олонтоо дурдагддаг боловч чухам “МНТ”д ганц Мөнх тэнгэрийн тухай дурдагдсан байдаг. Заарин тэнгэр нь Мөнх тэнгэрийн санааг илрүүлэгч хэмээн үзэхүл Мөнх тэнгэр нь нэгдсэн Монгол улсын үеийн гол шүтээн байсныг мэдэж болох юм.

“Мөнх тэнгэрийн сан”гийн сударт:

Монголчуудын эртний шүтээн мөнх тэнгэр нь:

“Аянд /Аранд/ мордвоос олз заяагч

Ардахь /нарадахи/ нутгийг минь бат болгогч

Агт морийг минь хүлэг болгогч

Хатуу үйлийг минь бүтээгч

Харь дайсанд хуяг болгогч

Халтургай зэмсгийг

Хатан болгогч...

... Мянга мянганыг мянгалан явагч

Мянган болдоо засан явагч

Түм түмнийг түмлэн явагч

Түүхий болдоо засан явагч” буюу аян дайн, байлдаан тулааны үед ивээн хамгаалж, зүрхийг нь хатан, морийг нь хүлэг, зэвсгийг нь болд болгон ард үлдсэн орон нутаг гэр бүлийг хамгаалан ивээх цэрэг дайны ивээгчийн үүрэг,

“Хулгай дээрмийг дарах

Ховор ховдгийг жавслагч/завсарлагч/

Хямрах тэмцэлдэхийг дарагч

Хэл амыг таслагч

Явдал хэргийг бүтээгч

Ядуусын зүдэнгийг мэдэгч

Ял ярбуйн/яхвагийн/ аюулаас ангижруулагч

Ноён хүнд номхноор үзүүлэгч

Нуур далай мэт олз оруулагч

## МОНГОЛЧУУДЫН ТЭНГЭР ШҮТЛЭГИЙН ХУВЬСАЛ

Хаан хүнд халуунаар үзүүлэгч” зэрэг нийгмийн ивээгчийн үүрэг,  
“Ганзагын /Хачигуны/ өлзийг өлзлүүлэн өгөгч  
Газаа/гадаа/ гэртгүй гэжүдэн өгөгч  
Гал усны аюулаас ангижруулагч  
Адгуусан өгөгч  
Аль санасныг бүтээгч  
Энэхэн биеийг тэтгэгч  
Эмгэг зовлонгоос ангижруулагч  
Араатан чоны аюулаас ангижруулагч” зэрэг байгалийн ивээгчийн үүрэг,  
“Тэнгэр хэмээн мөргөвөөс  
Тэвчилгүй тэмчин асрагч  
Тэргүүн толгой дээрээ сайтар өршөөгч”  
”Хорт шумнасын аюулаас ангижруулагч  
Дүдгэрийн аюулаас ангижруулагч  
Ад зэтгэр арилгагч  
Амь насыг уртатгагч  
Албин шумнас дарагч  
Хижиг гамшиг арилгагч

Хэрцгий шумнасыг дарагч” (Ринчен 2006: 83-86; Цолоо 1999: 13-26) зэрэг дээд шүтээн, ер бусын хүчний үүрэгтэйгээр өгүүлэгджээ. Нэгтгэн үзвэл, Мөнх тэнгэр нь нүүдэлчдийн оюун санаа, ахуй амьдрал, нийгэм улс төрийн бүхий л талыг хариуцах төгс үүрэгт шүтээн байсан байна. Монголчуудын цацал, үрс гаргах зан үйл, ус нуур тахилга, уул овоо тахилга зэрэг олон зан үйл нь уг углуургаараа тэнгэр шүтлэгтэй холбоотой байна. Үүнээс гадна Мөнх тэнгэрийг тусгай хэлтэй хэмээн ойлгож байсан нь Ордосын тэнгэр тахилгын үед “Их монгол”, “Бага монгол” зэрэг арван хоёр дууг тэнгэрийн хэлээр дуулах ёстой (Шаралдай 2001: 250) байдгаас харагдаж байна. Монголын бөө мөргөлд тэнгэрийг дээд шүтээн гэж үздэг бол Дархад бөөгийн уламжлалд “тэнгэр” хэмээн нэрлэгдсэн хэд хэдэн үндсэн ойлголт байгаагаас “Атаа таван тэнгэр”, Дээд тэнгэр, Ерэн есөн тэнгэр, Есөн тэнгэр, Жалам тэнгэр, Заарин тэнгэр, Мөнх тэнгэр, Оч хар тэнгэр, Өндөр төр, Тэнгэрийн бумал” (Пүрэв 2003) зэрэг олон ойлголт нь эртний тэнгэр шүтээнтэй үүрэг, шинж чанарын хувьд дүйдэг. “Тэнгэр хөллөсөн бөө” нь тэнгэрийн эрхэсүүдтэй нөхцөх буюу түүний хорлолоор бөө болсон бөөг хэлдэг. Ийм бөөгийн увьдсыг хамгийн хүчтэй гэх боловч лусад орсон сүнс онгодыг дарах чадалгүй гэж үздэг нь хожуу үеийн ойлголт бололтой. Дархадын Бөө

мөргөлд тохиолдох “тэнгэр” хэмээх дараагийн ухагдахуун нь “онгод тэнгэр” буюу нас барсан бөөгийн сүнс онгод, газар усны эздийг “тэнгэр” хэмээн нэрлэсэн байх нь олонтоо. Үүнийг эртний монголчуудын тэнгэр хэмээх утгатай дүйлгэн ойлгож болохгүй мэт санагдана Жишээ нь: Балгийн ногоон тэнгэр нь газрын эзэн, Зөнөг аавын ногоон тэнгэр нь Дархадын Ноё Зөнөг бөөгийн сүнстэй нөхцсөн лусын хаан, Тилигийн юм тэнгэр нь Тэнгис голын савд байдаг лусын хаадын нэгийг нэрлэдэг байна (Пүрэв 2003). Буриадын бөөгийн их шүтээн “Бух ноён баавай, Будан хатан ивий, Мангар хатан өхий буурал ээж, Соёдын ээж” зэрэг сүнс онгодыг ч “тэнгэр” хэмээн нэрлэсэн байдаг. Үүнээс гадна буддын шашны нөлөөгөөр үүссэн болов уу гэмээр үүрэгтэй “Эцгийн тэнгэр”, “Эхийн тэнгэр”, ”Гаравванчиг тэнгэр” (Монголын шарын бөө нарын шүтэх дээд тэнгэр Бурханы гэгээнтэй маргалдаад дийлдсэн гэдэг домогтой) (Дулам 1992: 44-45) зэрэг ойлголтууд ч байна.

Тэнгэр шүтлэгийн ул мөр ардын шүтлэгийн зан үйл ба билэг зүйн дурсгалд үлдсэн байх нь элбэг. Зуны эхэн сард тэнгэр анх дуугарахад монгол хот айлын настан эмгэн буюу гэрийн эзэгтэй даллагын хувиндаа сүү хийж, тэнгэрийн сумаа хувиндаа өлгөн гараад тэнгэрт цацал өргөхдөө “Зунаа нааш нь Зудаа цааш нь Өнөө нааш нь Өвлөө цааш нь” хэмээн шившдэг. Хаврын тэргүүн сарын шинийн нэгний өглөө эрт айл хотлын эрэгтэйчүүд овоонд гарах, индэрт гарах, ендэрт мөргөх зан үйл хийдэг. Орчин үед хот орон газарт ч хэдийгээр овоонд гарах аргагүй боловч олон хүн хавь ойрын өндөрлөг газарт гарсан байх нь үзэгддэг. Энэ зан үйл нь угтаа шинэ жилийн эхэнд тэнгэрт мөргөж, тэнгэртэй золгож мэнд айлтгаж буй утгатай юм. Ер нь монголчууд энгийн цагт ч уул толгойн орой, өндөрлөг газарт гарах нь эр хүний хийморь бадраана гэж үзэн тайлбарладаг нь тэнгэрт хамгийн ойр дөт оршин шадарлаж түүний хүчийг олох гэсэн эртний сэтгэлгээ одоо ч оршин буйг харуулах баримт юм. Үүнчлэн монголчуудын хэлц, зүйр цэцэн үгийн санд олонтоо тааралддаг тэнгэр хэмээх ойлголтууд нь эртний ивээгч тэнгэрийн утгаа хадгалсаар ирсэн байх нь олон тохиолдоно.

Орчин үеийн лам нарын зан үйлийн системд бөө мөргөл, эртний шүтлэгийн гаралтай овоо тахилга, ус нуур тахилга, хийморийн тахилга зэрэг нийгэм нийтийг хамарсан зан үйлүүд тохиолддог хэдий ч тэнгэр тахилга бие даасан шүтлэгийн зан үйл болоогүй нь сонирхол татаж байна. Хэдийгээр тэнгэртэй холбоотой тахилгын зан үйл байвч энэ нь ихэвчлэн хур бороо хүссэн шинжтэй байна. Зөвхөн өвөр Монголд “Хатагины атаа арван гурван тэнгэрийн тахилга” (Хурцбаатар 1990), Богд Чингэс хааны эзэн сүлдийг тахих үеийн тэнгэр тахилга бүрнээр үлдэн хоцорчээ.

1990 ээд оноос бөө мөргөл тодорхой хэмжээгээр сэргэн бөө удгадын зарим нь эртний тэнгэр шүтээн дахин сэргэж байгааг эс тооцвол шашны зан үйлийн хувьд бие даан оршихоо байсан учир шалтгааныг бид доорх байдлаар авч үзэж болох юм.

ХҮІ зууны үеэс Монгол оронд буддизм гуравдахь удаагаа дэлгэрэхдээ монголчуудын уугуул шүтлэг тэнгэр шүтээнийг голлосон бөө мөргөлийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан. Монголын ноёлох анги шарын шашныг дэмжиж байсан нь шарын шашин бөө мөргөлийг даван туулахад нэг гол хүчин зүйл болсон юм. Монголын түүх, хууль цаазын мэдээ, баримтаас үзэхэд монголын хаад ноёд лам бологсдын нийгмийн байр суурийг дээшлүүлэн “цоржийг хунтайжтай, тойн, шимнанц, увш, увсанз нарыг онигуд (бага тайж), нартай адил эрхтэй болгон хэрэв тэдэнд энгийн ард гар хүрвэл, үг хэлээр дайрвал хунтайж нарыг чингэсэнтэй адил шийтгэх явдлыг хуульчилж (Санан сэцэн 1961: 253-254, МУТ 2003: 129) байснаас гадна буддын шашны ном судрыг залсан, цээжилсэн, бөө мөргөлөөс сайн дураар татгалзсан хүмүүсийг урамшуулах замаар шарын шашныг дэмжихийн зэрэгцээ бөө мөргөлийг хавчин хяхаж, онгод авгалдай, бөө удгадын хувцас хэрэглэлийг хураан түлэх, онгод шүтээнээс нь татгалзуулах, тэр ч байтугай алж устгаж байсан тухай монгол ардын билэг зүйн мэдээнд олон таардаг. Түүнчлэн шарын шашны гадна талын сүр жавхлан, зан үйлийн уран нарийнаар бөөгийн мөргөлөөс хавьгүй давуу илүүгээр шүтлэгтэн олныг биедээ татаж чадсанаас тийнхүү ялав гэхэд бас л хангалтгүй мэт (Пүрэв 2003: 133)

Гэвч буддын шашин бөө мөргөлийг даван Монгол оронд дэлгэрсэн явдлыг зөвхөн нийгэм улс төрийн шалтгаан, ламын шашин төр засгийн дэмжлэгийг хүлээж байсантай нь холбон тайлбарлахад учир дутагдалтай байна. Энэ тэмцэлд бид лам нарын оруулсан үүрэг оролцоог дурдах ёстой юм. Дэлхий шашны түүхэнд шинэ шашин хуучнаа ноёлохдоо түүнийхээ гол шүтээнийг ямар нэгэн аргаар үгүйсгэх (чөтгөр шулам гэж зарлах), хуучин шүтээнийг шинээр тайлбарлан шинэ агуулга өгөн өөрийн бурханы хүрээний доод зэрэгт оруулах явдал элбэг тохиолдоно. Буддын шашны лам нар бөө мөргөлийн зан үйлийн хэлбэрийг бага зэрэг өөрчлөн буддизмын ертөнцийг үзэх үзэлд зохицуулан шинээр тайлбарлан ламын шашин хийгээд бөө мөргөлийн эрс ялгарлын заагийг бүдгэрүүлж байсан нь буддын шашин Монголчуудын дунд дэлгэрэн тархах үндсэн нөхцлийн нэг болсон байна. Түүнчлэн бөө мөргөлийн үндсэн шүтлэгийн агуулгыг шарын болон Төвдийн уугуул шашны ижил, төстэй ойлголтуудаар орлуулан өөрөөр хэлбэл, ард олонд үл анзаарагдах байдлаар солин шинэчлэх оролдлогыг олноор хийжээ. Хамгийн цэврээр үлдсэн гэгддэг Дархад бөөгийн ёсонд дархадын ихэнх бөө нар өөрийн хүч чадлын уг сурвалж Оч хар тэнгэр, Гал хар тэнгэрийг хар өнгөөр нь

Буддын шашны хангал бурхадын нэг Их хар буюу Гомбо Махгалитай дүйцүүлэн тайлбарласнаас одоо ч зарим бөө нар Гомбо Махгал бурханыг хүч чадлаа авдаг гэж үзсээр байна (Дулам 1992: 7)

Шарын шашин бөө мөргөлтэй тэмцэхдээ уламжлалт газар усны эзэд хэмээх ойлголтыг савдаг, шивдэг, навдаг, лус, юлха зэрэг төвдийн дүйх ойлголтоор орлуулах, бөө мөргөлийн хүчит онгодыг бурханы шашинд орж шашныг сахих тангараг авлаа хэмээн алдаршуулж зарлах (Таван хаан (Чоймаа нар 2000: 270)), зарим онгодод ламын сахил хүртээх (Даян дээрхэд гэнин сахил өргөсөн г.м.), бөө удган нарыг ламын шашны хангал бурхадын өмнөөс буудаг болгох (шарласан бөө), төвдийн уламжлалт шашны бөө болох чойжингуудыг оруулж ирэх зэрэг төрөл бүрийн аргаар тэмцэж байсан байна. Мөн ийм арга замаар бөө мөргөлийн үндсэн ойлголт болох “Бүхнийг үүсгэгч, бүхний хувь заяаг эрхшээгч, бүгдийг чадагч” “тэнгэр” гэсэн ойлголтыг буддын шашны болон энэтхэг төвдийн гаралтай ижил төстэй ойлголтуудаар орлуулсан нь “тэнгэр шүтлэг”ийг мөн чанарын хувьд үндсэндээ шахан зайлуулсан хэрэг болжээ. “Бүх ертөнц “кармагийн хууль” буюу “үйлийн үрийн хууль”д захирагдан энэ насанд хийсэн үйл бүхний үр дараа төрлийн хувь заяаг шийддэг, энэ нь ертөнцийн үүсэл мөхлийг ч шийддэг” хэмээн үзэх буддын шашны эш онол хийгээд “ертөнцийг бүтээж, түүний хувь заяаг эрхшээн барьж, хамаг бүхнийг заяагч, сайныг дэмжин саарыг шийтгэн орших “Тэнгэр эцэг” хэмээх ойлголт нь нэгэн зэрэг зэрэгцэн оршиж үл болох тул “тэнгэр шүтлэг”ийг халах явдал буддын шашны лам нарын гол зорилго байсан. Тиймээс эртний тэнгэр шүтлэгийн үндсэн санаа нь зөвхөн ардын шүтлэгийн сэтгэлгээнд ба бөө мөргөлийн зан үйлийн зарим нэгэн материалд дурдагдан үлдсэнээс бус, олонх тохиолдолд засвартай шинэ утгаараа тохиолдож байна. Буддын шашин дэлгэрсэн үеэс бөө мөргөлийн тэнгэр гэсэн ойлголт лам нарын номлолын нөлөөгөөр гажин хэд хэдэн шинэ маягийн үүрэгтэй тэнгэрс гарч ирсэн. Мөнх тэнгэр шүтээнийг үүрэг, хэлбэрийн хувьд орлон орж ирсэн эдгээр “шинэ” тэнгэрсээс “Гучин гурван тэнгэрийн орон”, “Найман их тэнгэрс”, “Заяан таван тэнгэр”, “Уулын тэнгэр” зэрэг ойлголтыг авч үзье.

Буддын шашны ном судруудад “гучин гурван тэнгэр нар” буюу ертөнцийн төвд орших Сүмбэр (санс. Sumeru. төвд. Ri rab) уулын оргил дээр найман эдийн тэнгэр (төвд. Nor lha brgyad) арван догшид (төвд. Drag po bcu) арван хоёр нар (төвд. Nyi ma bcu gnyis), хязгаар одны хоёр хөвгүүн (төвд. Tha skar gyi bu gnyis), тэргүүтэн гучин хоёр шадар эрхт хийгээд эрхт Хурмаст тэнгэр (төвд. Lha dbang brgya byin) лүгээ гучин гурван тэнгэр зугаа цэнгэлээр оршин байдаг тухай дурдсан байдаг. (Чоймаа нар 2000: 288) Мөн буддын шашинд “Найман их тэнгэр” хэмээх ойлголт байдаг нь аугаа хүчит

тэнгэрс буюу эртний ведийн шашнаас гаралтай энэтхэгийн тэнгэр нэр буюу Индра (төвд. brgya byin), Брахма (төвд. Tshangs pa), Вишнү (төвд. Khyab 'byug) Шива буюу Ишвара (төвд. dbang phyug), Камадева буюу Хүслийн тэнгэр (төвд. 'dod pa'I lha), Ганеш (төвд. Tshogs bdag), Вингириди (төвд. bhing ghi ri rdi), Садмуханумира (төвд. Gzhon nu gdong drug) (Чоймаа нар 2000: 99-100) зэргийг индуйзмын бурхадын пантеоноос үүргийг нь өөрчлөн шингээж авсан тэнгэрс юм. Их тэнгэрс нь хэдийгээр урт удаан настай, жаргал цэнгэлээр дүүрэн амьдарч, ямар нэг байдлаар хүмүүн буюу ертөнцийн хувь тавилан, үйл явдалд хөндлөнгөөс оролцох хүчтэй төдий ч эцсийн эцэст өөрсдөө “үхэж төрөх, үйлийн үрээ эдлэх” сансрын нэгэн төрөл эгэл амьтан болсон байна. Харин ч хүмүүн буян хийх ухамсартай төрснөөрөө зарим талаараа эдгээр тэнгэрээс ч давуу, чөлөө учрал бүрдсэн амьтан гэж үздэг байна. Эдгээр их тэнгэрсийг бурханы номд орж бурханы шашныг хамгаалах амлалт авсан гэж үзэх ба “Тэнгэр, дэлхий, газар ус тахих судар”-т “Ертөнц даяар гүрний эзэн Эсрэн Хурмаст нар ч Бурхан Шагжамунийн гэгээнээ сүслэн сөгдсөний тул мөн дэлхийн эзэд таны авралын орон мөнийг тольдож бурханы шашныг хүндлэн тахиж богд лам нарын өлмий батдаж бурсан олон хуврагийг тэтгэн хөгжүүлмүү” хэмээн өгүүлсэн байна (Агваандорж). Буддын шашинтнууд Христос шашны эзэн тэнгэр/Ертөнцийн эзэн, Мусульман шашны Аллах тэнгэр зэргийг эдэнтэй адил их тэнгэрс хэмээн үзэж тэднийг тэнгэртэн хэмээн нэрлэдэг байсан тухай мэдээ бий.

Тэгэхээр энэ төрлийн тэнгэрсийн тухай ойлголтыг монголчуудын бүхнийг чадагч Мөнх тэнгэрийн ойлголттой харьцуулан дүйлгэж болохгүй нь илт юм.

Лам нар тэнгэр гэсэн ойлголтыг халахдаа төвдийн буддизмын “Лха” хэмээх төстэй ойлголтыг оруулан иржээ. “Лха (Lha) гэдэг үг нь төвдийн “тэнгэр” (гэхдээ огторгуй бус, Зохиогч) гэсэн үг бөгөөд “Төвдийн домог зүйн ёсоор лха нь тэнгэр, газарт (ууланд) орших нэгэн зүйлийн хүмүүн бусын хүчин бөгөөд анх ертөнцийн өндөгнөөс үүссэн гэдэг. Лха нь мөн тодорхой газар нутгийг эрхшээн барьж байдаг газар усны эзэд юм. Төвдийн Бон шашны уламжлалд лха нь арван гурван тэнгэрт оршдог” гэнэ (Мелетинский 1990: 322).

Монголчуудын дунд нэлээд тархмал нэгэн ойлголт нь “Заяан таван тэнгэр”ийн тухай ойлголт юм. Заяа таван тэнгэр нь “Хүмүүн тус тусын бие лүгээ сүүдэр мэт хамт нөхөрлөж авран ивээдэг “лха” нар бөгөөд хүнийг эхээс төрөхөд хамт төрж, насан туршид нь ивээн тэтгэдэг тул тэдгээрийг шүтэж аврал даатгал явуулснаар харшлах шалтгаан бүгд арилж, өнгө зүс, бие махбод, үйлс бүтээл арвижин дэлгэрдэг” (Чоймаа

нар 2000: 474-475) тул “Хамт төрсөн таван тэнгэр, Лха таван тэнгэр, Сахиусан таван тэнгэр, Говийн Лха” гэх мэт олон янзаар нэрлэдэг ажээ.

Заяа таван тэнгэрийн үүргийг тодруулан үзвэл:

1. Орны тэнгэр, (төвд. Yul lha) Хүний оройд оршин сүр хүчийг өгч, орон гэрийг тэтгэнэ.
2. Эр тэнгэр (төвд. Po lha) Хүний баруун суганд оршин үйлсийг тэтгэнэ.
3. Эм тэнгэр (төвд. Mo lha) Хүний зүүн суганд оршин оюун билэг, өнгө зүсийг тэтгэнэ.
4. Дайсан тэнгэр (Дайчин тэнгэр) (төвд. dgra lha) Хүний баруун мөрөн дээр оршин цог хийморь, аз жаргалыг тэтгэнэ.
5. Амин тэнгэр (төвд. Srog lha) Хүний зүрхэнд оршин амь насыг дааж буян хишгийг ивээн тэтгэдэг ажээ.

Заяа таван тэнгэр нь хүнийг сахин хамгаалж байдгаараа Мөнх тэнгэрийн “Өдрийн цагт даган харах, Шөнийн цагт манан харах”, бөө мөргөлтний “Харсан тэнгэр”ийн үүргийг шилжүүлэн авсан болох нь тодорхой байна.

Заяан таван тэнгэрийн нэг Юлха буюу Орны тэнгэрийн нэртэй холбогдон уулын тэнгэр, нутгийн тэнгэр хэмээх ойлголтууд гарснаар тэнгэрийн байгалийн эрхшээгч үүргийг гүйцэтгэх болсон аж.

Энэ мэт шүүн үзвэл, тэнгэрийн шүтлэгийг ямар нэгэн талаар орлож болох Далха шүтлэг, Хийморь шүтлэг, Охин тэнгэрийн шүтлэг, Бороо урих, хорих зан үйл, Лус, Дэвжид найман аймаг, Дөрвөн Махаранзын зэрэг буддын шашны олон зан үйл байна. Мөн түүнээс гадна Ламын шашинтангууд зарим нэг ихэвчлэн догшин бурхадаа бөө мөргөлийн тэнгэрстэй сүлэлдүүлэн тайлбарлах явдал байна. Жишээ нь Яма бурханг Эрлэг хаантай, Очирваань бурханыг Чингэс хаантай, Далха тэнгэрийг Сүлд тэнгэр, Балданлхам бурханыг Охин тэнгэр, Намсрай бурханыг Эдийн тэнгэр хэмээдэг.

Дээр өгүүлснийг дүгнэн үзвэл, эртний монголчуудын үндсэн шүтээн олон талт үүрэгтэй, бүтээгч тэнгэрийн шүтлэгийг бөө мөргөлийн тулгуурын хувьд нь шарын шашны лам нар онцгойлон шахан өөрчилж, тайлга тахилгын зан үйлийн системийг нь халж устган, “тэнгэр” шүтээний үүргийг энэтхэг төвдийн ижил төстэй ойлголтуудаар солин хувиргаж буддын шашны ертөнцийг үзэх үзэл, домог зүйд тохируулан баяжуулж “Ертөнцийг бүтээн, хувь заяаг нь заагч” их, Мөнх тэнгэр “сансрын хүрдэнд эргэлдэж, үйлийн үрд захирагдах, хувь хүнийг даган хамгаалах сахиус болгон хувирчээ. Эртний тэнгэр шүтээний гүйцэтгэх үүргийг бусад олон шүтлэг, зан үйлийн системд



шилжүүлсэн байна. Гэвч эртний тэнгэр шүтлэгийн улбаа ардын шүтлэг, ардын зан үйлд хадгалагдсаар ирсэн байна гэж үзэж болох юм.

## НОМ ЗҮЙ

- Агваандорж цорж.* Тэнгэр, дэлхий, газар ус тахих судар. модон бар  
*Гэрэлбаатар Г.* 2001. Монголын уламжлалт шашин шүтлэг. УБ  
*Дулам С.* 1992. Дархад бөөгийн уламжлал. УБ  
*Мелетинский Е.М.* 1990. Мифологический словарь. М  
*Монгол улсын түүх* 2003. Гутгаар боть. УБ  
*Пүрэв О.* 2003. Монгол бөөгийн шашны нэр томъёоны тайлбар толь. УБ  
*Ринчен Б.* 2006. Монгол бөөгийн дуудлагууд. УБ  
*Санан сэцэн* 1961. Эрдэнийн товч. УБ  
*Сампилдэндэв Х.* 1985. Малчин ардын зан үйлийн уламжлал. УБ  
*Хэрээд Шаралдай* 2001. Чингэс хааны онгон шүтээний тайлга тахилга. УБ  
*Хурицаатар Ц.* 1990. Хатгины арван гурван атаа тэнгэрийн тайлга. Хөххот  
*Цолоо Ж.* 1999. Арван гурван Алтайн ариун сангууд оршвай. УБ  
*Чоймаа Ш., Тэрбиш Л., Бүрнээ Д., Чулуунбаатар Л.* 2000. Буддын шашны соёлын тайлбар толь. УБ  
*Rachewiltz J.de* 1972. Index to the Secret History of the Mongols., Bloomington

## SUMMARY

S.Byambadorj

### CHANGE AND EVOLUTION OF CULT OF “ETERNEL HEAVEN” OF MONGOLS

*In his article the author told about the “eternal Heaven”, ancient Mongolian worship, its roles and features and how it has been changed since the XVI century, when buddism started to flourish. In consequence of lamas activities, the eternal heaven, creator and nondependent, turned into the individual’s worship by Karma’s rules. Therefore worship of the sky has been kept in the people’s faith and customs.*